

## ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,  
2018 оны 9-р сарын 19-ний байдлаар


2018 оны 9-р сарын 19-ний байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 5.3 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.3 хувиар буурсан байна.

**Махны дундаж үнэ:** 2018 оны 9-р сарын 19-ний байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 8.8, үхрийн ястай махны үнэ 5.3 хувь, үхрийн цул махны үнэ 5.0 хувь, адууны ястай махны үнэ 2.4 хувь, ямааны ястай махны үнэ 10.4 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 0.9 хувь, үхрийн цул махны үнэ 0.5 хувь үхрийн ястай махны үнэ 0.4 хувиар буурсан бол бусад махны үнэ өөрчлөлтгүй байна.

2018 оны 9-р сарын 19-ний байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 6360 төгрөг, үхрийн /ястай/ мах 7780 төгрөг, үхрийн цул мах 9480 төгрөг, адууны /ястай/ мах 6125 төгрөг, ямааны /ястай/ мах 4700 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


**Зураг 1.** Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг



**Гурилын үнэ:** 2018 оны 9-р сарын 19-ний гурилын үнэ өмнөх сараас 1-р зэргийн задгай гурилын үнэ 0.2 хувиар буурсан бол бусад гурилын үнэ өөрчлөлтгүй байна. Гурилын үнийг өмнөх 7 хоногтой харьцуулахад гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

**Будаа, элсэн чихрийн дундаж үнэ:** 2018 оны 9-р сарын 19-ний байдлаар цагаан будааны үнэ өмнөх сараас 1.0 хувиар өссөн бол өмнөх 7 хоногтоос өөрчлөлтгүй байна. Элсэн чихрийн үнэ өмнөх сараас 0.5 хувиар буурсан бол өмнөх 7 хоногтоос өөрчлөлтгүй байна (Зураг2).

**Зураг 2.** Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



**Төмс, хүнсний ногооны дундаж үнэ:** 2018 оны 9-р сарын 19-ний байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 30.0 хувь, луувангийн үнэ 23.6 хувь, байцааны үнэ 16.6 хувь, хүрэн манжингын үнэ 37.6 хувь, сонгины үнэ 4.4 хувиар тус бүр буурсан байна.

Өмнөх 7 хоногоос төмс хүнсний ногооны дундаж үнэ өөрчлөлтгүй байна.

**Сүү, өндөг, ургамлын болон цэцгийн тосны дундаж үнэ:** 2018 оны 9-р сарын 19-ний байдлаар сүүний үнийг өмнөх сартай харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.2 хувиар буурч, элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.3 хувиар өссөн бол задгай сүүний өөрчлөлтгүй байлаа. Өмнөх 7 хоногоос сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сараас 0.8 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. Цэцгийн тосны үнэ өмнөх сараас 8.5 хувиар буурсан бол өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байлаа.

**ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газар  
2018 оны 9-р сарын 19**